



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

“Улаанбаатар-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-49, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/452 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулах, аялагч амрагчдыг нэг дороос аяллын талаар бүх мэдээ мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор олон улсын аялал жуулчлалын “Улаанбаатар-2018” үзэсгэлэнг 2018 оны 06 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнд зохион байгуулсугай.

2. Олон улсын аялал жуулчлалын “Улаанбаатар-2018” үзэсгэлэнг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэнг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 16 973 700 /Арван зургаан сая есөн зуун далан гурван мянга долоон зуун/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Жавхлан/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ


Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 18 өдрийн А/40 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

9284025 СБТ 8936 1118263502

ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН “УЛААНБААТАР-2018”
ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Д.Жавхлан	/Мэдээлэл, сурталчилгааны хэлстийн дарга /
Гишүүд	А.Эрдэнэцогт	/Маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн/
	З.Оюуншүр	/Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/
	Г.Азжаргал	/Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга	Б.Ербахыт	/Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн/

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 18 өдрийн А/40 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



“УЛААНБААТАР-2018” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2018 оны 05 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз засал /лед дэлгэц, хөгжмийн түрээс 2 өдөр/	2	2 000 000	4 000 000
2	Майхны түрээс (3x3м ²) /2 хоног/	21	80 000	3 360 000
3	Арга хэмжээний танилцуулга нугалбар /үзэсгэлэнгийн хөтөлбөр мэдээлэлтэй/	1000	400	400 000
4	Шторк хийлгэх 20-30 сек	1	1 500 000	1 500 000
5	Хөтлөгч 2 өдөр	2	800 000	1 600 000
6	Урлагийн тоглолт	2 өдөр 4 удаа	250 000	1 000 000
7	Туслах ажилчдын цалин	5 хүн /2 өдөр/	20 000	200 000
8	Лекц унших багш нарын цалин	5	100 000	500 000
9	Цахилгааны төлбөр	2 өдөр	-	-
10	Хог цэвэрлэх төлбөр	2 өдөр	-	-
11	Хөмсгөн хаяг /5x0.3м хэмжээтэй/	50	9000	450 000
12	Мандат хэвлэлт /гэр, оосор/	200	1 000	200 000
13	Тайзны хажуу болон үүдэнд байрлуулах хөтөлбөр хэвлүүлэх /6 хэвлэл нийт 54 м.кв/	6	9000	486 000
14	Төлөөлөгчдийн зочид буудлын төлбөр /3 өдөр/	10 хүн	70 000 100 000	2 460 000
15	Гадна самбарт баннер хэвлүүлэх, байршуулах	-	817 700	817 700
Нийт			16 973 700	